



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 13 өдөр

Дугаар А/575

Хэрлэн сум


Шүүхийн шинжилгээний хэлтсийн
үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2,14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын аравдугаар хуралдааны 2023 оны 02 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсаны дагуу хууль сахиулах байгууллага буюу Шүүхийн шинжилгээний хэлтсийн үйл ажиллагаанд шаардлагатай байгаа техник, тоног төхөөрөмж авахад шаардлагатай 9,000,000 (есөн сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Б.Дарханбаатар)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ